



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар АН7

Хэрлэн сум

Дэд бүтцийн ажлын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4-ийн а, б, в, г, д, 29.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хэмжээнд дэд бүтцийн ажлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах замаар үндэслэлтэй, шуурхай шийдвэр гаргах, зорилго бүхий Дэд бүтцийн ажлын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Нарийн бичгийн
дарга:

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн
хэлтсийн дарга

Гишүүдэд:

-Аймгийн Засаг даргын орлогч

-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын
Захирагч

-Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
дарга

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

-Орон нутгийн өмчийн газрын дарга

-Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын захирал

-Хэнтий-Ус ХХК-ий захирал

-Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ий Хэнтий аймаг дахь
газрын дарга

Хоёр. Дэд бүтцийн ажлын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/122 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 161

ДЭД БҮТЦИЙН АЖЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Аймгийн хэмжээнд дэд бүтцийн ажлуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах замаар үндэслэлтэй, шуурхай шийдвэр гаргахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Дэд бүтцийн ажлын зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга байх бөгөөд түүний эзгүйд аймгийн Засаг даргын орлогч зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагаа

- 2.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.
- 2.2. Хурлаар дэд бүтцийн ажлуудын төлөвлөлт, хэрэгжилтийн явц болон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, харилцан мэдээлэл солилцох, дэд бүтцийн холбогдолтой бусад асуудлыг хэлэлцэнэ.
- 2.3. Дэд бүтцийн ажлын зөвлөл нь жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд 14 хоногт нэг удаа, жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд 7 хоногт нэг удаа, Пүрэв гараг бүрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын зөвлөлийн өрөөнд хуралдана.
- 2.4. Хурлын үйл ажиллагааны бэлтгэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хангах бөгөөд хуралдааныг зөвлөлийн дарга удирдан явуулна.
- 2.5. Зөвлөлийн гишүүд хэлэлцэх асуудалтай нарийн танилцаж, санал дүгнэлт гарган хуралдаанд идэвхитэй оролцох үүрэгтэй.
- 2.6. Зөвлөлийн гишүүд хуралд оролцох боломжгүй тохиолдолд зөвлөлийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй бөгөөд өөрийн албан үүргийг орлох албан тушаалтныг оролцуулна.
- 2.7. Зөвлөлийн дарга хэлэлцэх асуудлын онцлог, хамрах хүрээг харгалзан зөвлөлийн гишүүдээс гадна төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн удирдлага, холбогдох албан хаагчийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр хурлыг хуралдуулж болно.

Гурав. Зөвлөлийн хурлын тэмдэглэл

- 3.1. Зөвлөлийн хурлаас тэмдэглэл гарах бөгөөд тэмдэглэлийг Дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн хөтөлж, тэмдэглэлд тусгагдсан асуудлыг холбогдох албан тушаалтан, байгууллага, иргэдэд хүргүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавих ажлыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хариуцна.
- 3.2. Тэмдэглэлд тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, зөвлөлийн гишүүдийн ирцийн байдал, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой холбогдон гарсан асуулт, хариулт, санал дүгнэлтийн эцсийн шийдвэрийг тодорхой бичнэ.